



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/507

Улаанбаатар хот

“Эрүүл шүд” арга хэмжээг
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023 оны 322 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд суралцагчдыг шүд, амны хөндийн эрүүл ахуй сахих, хоол, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэсний дараа шүдээ угаах дадал хэвшилд сургах “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлсүгэй.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох нэгж, байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.

2.1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байранд эрүүл ахуйн шаардлага хангасан шүд угаах орчин/хэсэг бий болгох ажлыг 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт;

2.2. хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг шүд зөв угаах дадал хэвшилд сургах, шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, өвчилсөн шүдийг эмчлүүлэх арга хэмжээг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй хамтран зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт;

2.3. сургуулийн өдрийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байгаа анги бүлэг, суралцагчийн тоо, шүд угаах хэсгийн багтаамж, нэг хүүхдэд ногдох угаагуурын хүртээмж зэргийг тооцож хичээл хоорондын засварлагааны үргэлжлэх хугацааг ялгаатай байхаар тогтоон, шүд угаах цагийн уян хатан зохицуулалт хийж, шүдийг зөв угаах дадал хэвшилд сургах зан үйл төлөвшүүлэх ажлыг эхлүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт;

2.4. шүд угаах хэсэг бий болгох, орчинд тавигдах шаардлагыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулан баталж, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хүргүүлэхийг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газрын дарга нарт;

2.5. шүд, амны эрүүл ахуйг сахих, шүдийг зөв угаах арга зүйн зөвлөмж, гарын авлага боловсруулж, хүүхдийн цэцэрлэгийн арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн холбогдох мэргэжлийн багш, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газрын байгалийн ухааны сургалт хариуцсан арга зүйчдэд сургалт зохион байгуулахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль (Н.Хүрэлбаатар)-д;

14231 2045

2.6. энэ тушаалын 2.5-д заасан сургалтаар бэлтгэгдсэн багш, арга зүйчдийн оролцоотой харьяа нутаг дэвсгэрийн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмч, удирдах ажилтанд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулахыг аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газрын дарга нарт;

2.7. шүд, амны эрүүл ахуй сахихтай холбогдох сургалтын биет болон цахим орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, контент бүтээх тэдгээрийг хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт;

2.8. суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагчдад шүд, амны эрүүл ахуйг сахих, эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдлэг, дадал, чадвар эзэмшүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг суралцагчдын оролцоонд тулгуурлан зохион байгуулах, “Эрүүл шүд” арга хэмжээг байгууллагын түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт, хэрэгжилтэд хяналт тавьж шаардлагатай хариу арга хэмжээ авах, явц, үр дүнг Боловсролын ерөнхий газарт тайлагнаж ажиллахыг аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газрын дарга нарт.

3. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд шүд угаах хэсэг бий болгоход шаардагдах зардлыг улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгах, гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломжийг судалж холбогдох арга хэмжээ авахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг), Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр)-т үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН